



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/394

Булган сум

Волейболын насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Волейболын спортыг сурталчлан таниулах, иргэдийн бие бялдар, авьяас, ур чадварыг хөгжүүлэх, спортоор хичээллэх идэвх, сонирхлыг дэмжих зорилгоор Баяннуур суманд 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс 08-ны өдрүүдэд зохион байгуулагдах насанд хүрэгчдийн волейболын аймгийн аварга шалгаруулах тэмцээний үйл ажиллагааны зардалд 2,000,000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах зардлыг Аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Наранбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6325010555